

**ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2024 он

Гарчиг

Нэг. Ерөнхий үндэслэл

Хоёр. Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

- 2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- 2.2. Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох
- 2.3. Хуулийн этгээдийн зардлын тоон үзүүлэлтийг тооцох
- 2.4. Хуулийн этгээдийн нийт зардлын дүнг тооцож гаргах
- 2.5. Хуулийн этгээдийн зардлыг хялбарчлах буюу бууруулах боломжийг шалгах
- 2.6. Хуулийн этгээдийн нэмэлт зардлыг тооцох

Гурав. Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлын тооцоо

- 3.1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- 3.2. Иргэний зарцуулах цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- 3.3. Иргэний зардлын тоон үзүүлэлтийг тооцох
- 3.4. Иргэний зардлын нийт дүнг тооцох
- 3.5. Иргэний зардлыг хялбарчлах буюу бууруулах боломжийг шалгах

Дөрөв. Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

- 4.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох
- 4.2. Төрийн байгууллагын ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох
- 4.3. Төрийн байгууллагаас гарах зардлыг урьдчилан тооцох
- 4.4. Төрийн байгууллагуудын зардлыг нэгтгэн тооцох
- 4.5. Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг тодорхойлох

Тав. Дүгнэлт.

Нэг. Ерөнхий үндэслэл

Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл батлагдан хэрэгжсэнээр хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагаас гарах зардлын тооцооны тайлан

Монгол Улсын “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасан байна.

Үүний дагуу Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг дээр дурдсанчлан “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 12.1.4-т заасан буюу Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 тоот “Аргачлал батлах тухай” Тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид аргачлал гэнэ/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагуудад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, зардлыг бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл батлагдсанаар зардал үүсгэгч этгээд болох хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад тодорхой үүрэг бий болгосон, түүнийг хэрэгжүүлэхэд мөнгөн зардал шинээр бий болохоор тусгагдсан эсэхийг шалгана.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2 дугаар зүйлд “Тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ.

Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо мэдээ байхгүй бол баримжаалж тооцно.” гэж заасан болон 4.4.2 дугаар зүйлд “Зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно.” гэж тус тус заасныг үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, тухайн салбарын мэргэжилтний мэдээлэл, саналыг баримтлан баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтооно.

**Хоёр. Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл
батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал**

Энэ хэсэгт тухайн хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- Хуулийн этгээдийн зардлыг тооцох
- Хуулийн этгээдийн зардлын тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт зардлын дүнг тооцож гаргах
- Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах
- Хуулийн этгээдийн нэмэлт зардлыг тооцох

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж, уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно.” гэж заасан.

Хуулийн төсөлд **хуулийн этгээдэд** үүрэг болгосон буюу шууд зардал үүсгэх болон шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж үзэж болох агуулга бүхий дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1	11.1.	Спорт-сургалтын зориулалтаар галт зэвсэг эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд нь галт зэвсгээ энэ хуулийн 15.3-т заасны дагуу бүртгүүлнэ. Энэ хуулийн 5.1-д заасан холбоо нь холбооны гишүүнчлэл, галт зэвсгийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгүүлнэ.
2	11.7.	Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэг, сум ашигласан, буудлага үйлдсэн тухай бүртгэл, галт зэвсэг, сум, галт хэрэгсэл хүлээлгэн өгөх тооцооны хуудастай байна.
3	11.10.	Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь өөрийн өмчилж,

		эзэмшиж байгаа галт зэвсэг, сумны тооллогыг сар бүр явуулж, бүрэн бүтэн байдалд нь хяналт тавьж, цагдаагийн байгууллагад тайланг хүргүүлнэ.
4	12.1.	Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсгийг бүртгүүлсэн зориулалтаар нь аюулгүй ажиллагааг ханган ашиглах эрхтэй.
5	12.6.	Галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд зориулалтын галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах байр, буудлага үйлдэх байгууламж /тир/-тай байна.
6	12.8.	Галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй хуулийн этгээд нь спорт-сургалтын галт зэвсгийг зөвхөн багш, дасгалжуулагч, зааварлагчийн хяналт, удирдлага дор буудлага үйлдэх байгууламж /тир/-д 14 нас хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр спортын буудлага хийлгүүлж болно.
7	12.9.	Энэ хуулийн 12.8-д заасан үйл ажиллагааны улмаас учирсан аливаа хохирлыг галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй хуулийн этгээд хариуцна.
8	13.1.	Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4-т заасан зориулалтаар, аюулгүй ажиллагааг ханган ашиглах эрхтэй.
9	13.2	Иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлийг эзэмших, ашиглах тохиолдолд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулна.
10	13.4.	Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд зориулалтын буудлага, харваа үйлдэх байгууламж /тир/-тай байна.
11	13.5.	Иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэлийн гэрчилгээний хамт зориулалтын сав хайрцагт хийж, гохыг цоожилж, сумыг тусад авч явна.
12	15.3.	Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд галт зэвсэг худалдан авсан, эсхүл улсын хилээр оруулсан бол ажлын таван өдрийн дотор хуулийн этгээдийн оршин байгаа газрын нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлэх
13	16.1.	Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг өмчлөх, эзэмших зорилгоор худалдаж авсан, улсын хилээр оруулсан иргэн, хуулийн этгээд ажлын таван өдрийн дотор оршин

		суугаа газрын нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж бүртгүүлнэ.
14	16.2.	Иргэн, хуулийн этгээд өмчлөх, эзэмших зорилгоор худалдаж авсан, улсын хилээр оруулсан хийн бууны гол төмрөөс хошуу буюу үрлийн шидэгддэг агшины кинетик энерги нь 7.5 буюу түүнээс дээш жоуль, хавчаахай /нумт буу/ нь зэвт хошуу бүхий сумтай, нумны хөвчний татах хүч нь 43 кг буюу түүнээс дээш галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлд хамааруулж, иргэн, хуулийн этгээд оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж бүртгүүлнэ.
15	16.3.	Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдан борлуулахаас өмнө тэдгээрийн нэр, төрөл, загвар, тоо ширхэгийг тусгасан мэдээллийг цагдаагийн байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ.
16	18.2.	Галт зэвсэг өмчлөгч хуулийн этгээд галт зэвсгийг зориулалтын төхөөрөмжилсөн өрөөнд, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ /сав/-нд хадгална.
17	18.3.	Иргэн, хуулийн этгээд арав, түүнээс дээш тооны галт зэвсгийг өмчилж, эзэмшиж байгаа бол аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоноглогсон өрөөнд галт зэвсгийг сумнаас тусад нь зориулалтын шүүгээнд хадгална.
18	18.6.	Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд галт зэвсгийг өмчилж, эзэмшиж байгаа бол аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоноглогсон зориулалтын агуулахад галт зэвсэг, сумыг тус тусад нь хадгалах бөгөөд үйл ажиллагаагаа явуулдаг байр нь Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хамгаалалттай байна.
19	19.5.	Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хуулийн этгээд галт зэвсэг өмчлөхийг хориглоно.
20	19.6.	Энэ хуулийн 7.2-т заасан жагсаалтад орсон галт зэвсгийг иргэн, хуулийн этгээд улсын хилээр нэвтрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах, эзэмших, өмчлөхийг хориглоно.
21	20.4.	Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь өөрийн ажиллуулж байгаа буудлага үйлдэх байгууламж /тир/-д ашиглуулах зориулалтаар сум худалдаалах, импортлох эрхтэй байна
22	20.6.	Энэ хуулийн 20.5-д заасан хуулийн этгээд сумыг өөрийн ажиллуулж байгаа буудлага үйлдэх байгууламжаас өөр газар худалдаалах, ашиглуулахыг хориглоно.

23	20.8.	Монгол Улсад галт зэвсэг, сум нийтэд худалдах төв /цаашид “Төв” гэх/ ажиллуулах эрхийг улсын хэмжээнд гурваас илүүгүй хуулийн этгээдэд олгох бөгөөд Төв ажиллуулах эрхийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
24	20.14.	Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигч нь тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг бусдад худалдах, удирдах болон гүйцэтгэх удирдлага өөрчлөх замаар бусдад шилжүүлэх тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
25	22.1.	Иргэн, хуулийн этгээд нь борлуулагчаас энэ хуулийн 4.1.1-4.1.4-т заасан галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, галт зэвсгийн гол төмөр, их бие, замаг, цохигч төмөр худалдаж авах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр болон цахимаар гаргана.
26	22.3.	Борлуулагч энэ хуулийн 22.2-т заасан зөвшөөрлийг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд галт зэвсэг худалдана.
27	22.4.	Борлуулагч энэ хуулийн 9.1-д заасан иргэн, хуулийн этгээдэд галт зэвсэг, сум худалдах бөгөөд иргэн, хуулийн этгээдийн худалдан авсан галт зэвсэг, сумны талаарх мэдээллийг цахимаар болон цаасаар хөтөлж, цагдаагийн байгууллагад сар бүр тайланг хүргүүлнэ. Бүртгэлийн загварыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.
28	22.5.	Борлуулагч галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг иргэн, хуулийн этгээдэд худалдахдаа худалдан авсан тоо, төрөл, марк, дугаарын тэмдэглэл бүхий тодорхойлолтыг олгоно.
29	23.1.	Иргэн, хуулийн этгээд өөрийн өмчид байгаа галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг энэ хуульд заасан шаардлага хангасан иргэн, хуулийн этгээдэд худалдаж болно.
30	25.1.	Галт зэвсэг, сум, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.
31	25.4.	Төв ажиллуулах хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:
32	29.1.	Шалгарсан хуулийн этгээд нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай[2] хуулийн 13.1.1, 13.1.2-т заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлж, баримтыг Комиссын нарийн бичгийн даргад өгнө.
33	30.1.	Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд нь орон нутагт салбартай байж болно. Төвийн салбар нь энэ хуулийн 25.4-т заасан шаардлагыг хангасан байна.

		Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд нь салбар нээх хүсэлтийг Комисст гаргана.
34	31.2.	Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд болон борлуулагч нь Төвийн зохион байгуулалт, аюулгүй байдлын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
35	31.3.	Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд энэ хуулийн 31.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангаж ажиллана:
36	31.4.10.	алдагдсан, дутсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн талаар тагнуул, цагдаагийн байгууллагад мэдсэн даруйдаа мэдэгдэх;
37	31.4.11.	Борлуулагч нь энэ хуулийн 20.11-д заасан баримт бичгийг авч энэ хуулийн 22.4-т заасан хугацаанд цагдаагийн байгууллагад хүргүүлэх
38	32.1.	Галт зэвсэг өмчлөх эрхтэй Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрөө өмчлөх зорилгоор энэ хуулиар хориглоогүй нэг галт зэвсгийг жилд нэг удаа улсын хилээр оруулах эрхтэй. Иргэн өөрөө өмчлөх зорилгоор оруулж ирсэн галт зэвсгийг оруулж ирснээс хойш гурван жилийн дотор бусдад худалдах, бэлэглэхийг хориглоно.
39	32.8.	Энэ хуулийн 32.3-д заасан галт зэвсэг, сумыг иргэн, хуулийн этгээд эд бэлэглэх, өвлүүлэх, худалдах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
40	32.9.	Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшилд бүртгэлтэй галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг энэ хуулийн 25.2-т заасан шаардлага хангасан агуулахад хадгалах бөгөөд спортын тэмцээнд оролцох, бэлтгэл хийхээс бусад иргэн, хуулийн этгээдэд ашиглуулах, хадгалуулахыг хориглоно.
41	36.2.	Үйлдвэрлэгч нь цагдаагийн төв байгууллагад үйлдвэрлэсэн, экспортолсон, худалдсан, устгасан галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны нэр төрөл, сери /цуврал/ дугаар, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийг сар бүр хүргүүлнэ.
42	37.2.	Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх хуулийн этгээд нь үйл ажиллагааны эрсдэл, иргэний амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулсан байна.
43	39.1.	Буудлага үйлдэх байгууламж /тир/" нь битүү, хагас битүү, задгай байж болно.
44	43.1.	Галт зэвсэг, сум худалдах төв нь битүү тиртэй байна.
45	43.6.	Буудлагын тир болон зэвсэг хадгалах өрөө нь бусад өрөө тасалгаануудаас тусдаа байрлана.
46	51.5.	Харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум ашиглан харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд энэ хууль хүчин төгөлдөр

		болсноос хойш нэг жилийн дотор зөвшөөрлөө нөхөн авна.
--	--	---

Хэдийгээр хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн дээрх зохицуулалтууд тусгагдсан боловч эдгээр нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа

- Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр батлан гаргаж, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр, 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, нийтдээ 6 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан “Галт зэвсгийн тухай” хууль /шинэчилсэн найруулга/
- Монгол Улсын Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/219 тоот тушаалын хавсралтаар баталсан “Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам” болон бусад холбогдох эрх зүйн актын хүрээнд зохицуулагдаж байгаа харилцаа байна.

Өөрөөр хэлбэл дээрх зохицуулалтууд нь зардал шинээр үүсгэх зохицуулалт биш хууль болон эрх бүхий субъектын тогтоол, шийдвэрээр баталсан эрх зүйн актын дагуу хэрэгжиж байгаа, практикт хэвшсэн зохицуулалт байна.

Харин Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх хуулийн этгээд нь үйл ажиллагааны эрсдэл, иргэний амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулсан байна.” гэж заасны дагуу галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь ажилтнуудаа даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээх зохицуулалт шинээр тусгагдсан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх ажиллагаа нь даатгалын байгууллагатай тухайн тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд даатгалын гэрээ байгуулан зах зээлийн тухайн үеийн ханшаар ажилчдынхаа тоогоор даатгал төлөх үүрэг хүлээх тул урьдчилан тооцоолох боломжгүй байна.

Мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 18 дугаар зүйлийн 18.6-д “Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг **хуулийн этгээд** галт зэвсгийг өмчилж, эзэмшиж байгаа бол аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоногдосон зориулалтын агуулахад галт зэвсэг, сумыг тус тусад нь хадгалах бөгөөд үйл ажиллагаагаа явуулдаг байр нь Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хамгаалалттай байна” гэж заасан хуульд заасан шаардлагыг хангахын тулд гэрээт харуул хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээний дагуу харуул хамгаалалтад төлбөрийг төлж хамрагдах зохицуулалт шинээр үйлчлэх бөгөөд энэ нь мөн гэрээгээр зохицуулагдах тул хуулийн этгээдээс гарах зардлыг шууд тооцох боломжгүй байна.

Шинэчилсэн төсөлд тусгагдсан хуулийн этгээдэд үүрэг болгосон бусад заалтууд нь хориглосон агуулгатай буюу эс үйлдэхүйг үүрэг болгосноороо хуулийн этгээдэд нэмэлт зардал гарах зохицуулалт биш болно.

Гурав. Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараах дарааллыг баримтална. Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах

Энэ үе шатанд Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөлд тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг болон түүний мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тодорхойлж, иргэнд үүсэх зардлын цаг хугацааны ачааллаар тооцсон болно.

Харин хуулийн төсөлд иргэний гүйцэтгэх үүргийг тусгасан дараах зохицуулалтууд байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1	5.1.	Спорт-сургалтын зориулалтаар галт зэвсэг өмчлөх иргэн нь мэргэжлийн буудлага-спортын холбооны гишүүнчлэлтэй байна.
2	9.1.	Хуульд өөрөөр заагаагүй бол 21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг санаатай үйлдэж байгаагүй, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.4 дахь заалтад заасан галт зэвсэг өмчилж болно.
3	9.2.	9.2.Энэ хуульд заасан шаардлага хангасан иргэн , хуулийн этгээд энэ хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу галт зэвсгээ бүртгүүлж, 17 дугаар зүйлд заасан галт зэвсгийн гэрчилгээ авснаар галт зэвсэг өмчлөх эрх үүснэ.
4	10.1.	Энэ хуулийн 9.1 дэх хэсэг заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн энэ хуулийн 4.1.2, 4.1.3 дахь заалтад заасан галт зэвсэг эзэмшиж болно.
5	11.1.	Спорт-сургалтын зориулалтаар галт зэвсэг эзэмшиж байгаа иргэн , хуулийн этгээд нь галт зэвсгээ энэ хуулийн 15.3-т заасны дагуу бүртгүүлнэ.

6	11.7.	Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн , хуулийн этгээд нь галт зэвсэг, сум ашигласан, буудлага үйлдсэн тухай бүртгэл, галт зэвсэг, сум, галт хэрэгсэл хүлээлгэн өгөх тооцооны хуудастай байна.
7	11.10.	Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн , хуулийн этгээд нь өөрийн өмчилж, эзэшиж байгаа галт зэвсэг, сумны тооллогыг сар бүр явуулж, бүрэн бүтэн байдалд нь хяналт тавьж, цагдаагийн байгууллагад тайланг хүргүүлнэ.
8	12.1.	Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсгийг бүртгүүлсэн зориулалтаар нь аюулгүй ажиллагааг ханган ашиглах эрхтэй. Иргэн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа галт зэвсгээ амь бие, эд хөрөнгийг араатан, амьтнаас хамгаалах зорилгоор ашиглаж болно.
9	12.3.	Галт зэвсэг өмчлөгч иргэн галт зэвсгээ энэ хуулийн 9.1-д заасан шаардлага хангасан иргэнд түр хугацаагаар ашиглуулж болно.
10	13.1.	Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4-т заасан зориулалтаар, аюулгүй ажиллагааг ханган ашиглах эрхтэй. Иргэн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг амь бие, эд хөрөнгийг араатан, амьтан, бусад гадны халдлагаас хамгаалах зорилгоор ашиглаж болно.
11	13.2.	Иргэн , хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлийг эзэмших, ашиглах тохиолдолд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулна.
12	13.4.	Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд зориулалтын буудлага, харваа үйлдэх байгууламж /тир/-тай байна.
13	13.5.	Иргэн , хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэлийн гэрчилгээний хамт зориулалтын сав хайрцагт хийж, гоxyг цоожилж, сумыг тусад авч явна.
14	15.1.	Иргэн нь ан агнах, спорт-сургалт, үзмэр цуглуулгын галт зэвсэг, гол төмөр худалдаж авсан, улсын хилээр оруулсан бол ажлын таван өдрийн дотор галт зэвсгээ оршин суугаа газрын нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.
15	15.6.	Галт зэвсэг өмчлөгч иргэн оршин суугаа газрын хаягаа өөрчилсөн бол нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажлын 10 өдрийн дотор мэдэгдэж галт

		зэвсгээ бүртгэлээс хасуулж, шилжин очсон газрынхаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажлын арван өдрийн дотор бүртгүүлнэ.
16	16.1.	Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг өмчлөх, эзэмших зорилгоор худалдаж авсан, улсын хилээр оруулсан иргэн , хуулийн этгээд ажлын таван өдрийн дотор оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж бүртгүүлнэ.
17	18.1.	Галт зэвсэг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн галт зэвсгийн гох, эсхүл замгийг цоожилж, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ /сав/-нд хадгалах ба галт зэвсгээс замгийг салгах боломжтой бол замгийг салгаж хадгална.
18	18.3.	Иргэн , хуулийн этгээд арав, түүнээс дээш тооны галт зэвсгийг өмчилж, эзэмшиж байгаа бол аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоноглогсон өрөөнд галт зэвсгийг сумнаас тусад нь зориулалтын шүүгээнд хадгална.
19	19.3.	Энэ хуулийн 12.6-д заасан жагсаалтын дагуу галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согогтой иргэн галт зэвсэг өмчлөхийг хориглоно.
20	19.4.	Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахыг хориглоно.
21	19.6.	Энэ хуулийн 7.2-т заасан жагсаалтад орсон галт зэвсгийг иргэн, хуулийн этгээд улсын хилээр нэвтрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах, эзэмших, өмчлөхийг хориглоно.
22	22.1.	Иргэн , хуулийн этгээд нь борлуулагчаас энэ хуулийн 4.1.1-4.1.4-т заасан галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, галт зэвсгийн гол төмөр, их бие, замаг, цохигч төмөр худалдаж авах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр болон цахимаар гаргана.
23	22.6.	Иргэн , хуулийн этгээд худалдаж авсан галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслээ энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлж галт зэвсгийн гэрчилгээ авна.
24	23.1.	Иргэн , хуулийн этгээд өөрийн өмчид байгаа галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг энэ хуульд заасан шаардлага хангасан иргэн, хуулийн этгээдэд худалдаж болно.
25	23.3.	Иргэн , хуулийн этгээд галт зэвсгийг худалдсан талаар тухайн галт зэвсгийг бүртгэлд авсан цагдаагийн байгууллагад ажлын таван өдрийн дотор мэдэгдэж, тэмдэглэл хийлгэн бүртгэлээс хасуулна.
26	23.5.	Иргэн , хуулийн этгээд өөрийн сайн дураар галт зэвсэг, сумыг цагдаагийн байгууллагад шилжүүлж болно.

27	32.1.	Галт зэвсэг өмчлөх эрхтэй Монгол Улсын иргэн , хуулийн этгээд өөрөө өмчлөх зорилгоор энэ хуулиар хориглоогүй нэг галт зэвсгийг жилд нэг удаа улсын хилээр оруулах эрхтэй. Иргэн өөрөө өмчлөх зорилгоор оруулж ирсэн галт зэвсгийг оруулж ирснээс хойш гурван жилийн дотор бусдад худалдах, бэлэглэхийг хориглоно.
28	32.3.	Энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр оруулж болно.
29	32.8.	Энэ хуулийн 32.3-д заасан галт зэвсэг, сумыг иргэн, хуулийн этгээдэд бэлэглэх, өвлүүлэх, худалдах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
30	33.1.	Галт зэвсэг ашиглах спортын тэмцээн, сургалтад оролцох, ан агнах зорилгоор Монгол Улсын иргэн, гадаадын иргэн өөрийн өмчлөл, эзэмшлийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хүсэлтийг цагдаагийн төв байгууллагад гаргах бөгөөд уг хүсэлтэд хилээр нэвтрүүлэх галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн нэр, төрөл, тоо, дугаар, улсын хилээр оруулах, гаргах хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтыг заасан байна.
31	35.1.	Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл авсан иргэн , хуулийн этгээд гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад шаардагдах бичиг баримтын хамт бүрдүүлсэн байна.
32	44.2.	Галт зэвсэг өмчлөгч иргэн нас барсан, эсхүл хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд галт зэвсгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, эсхүл хураах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
33	44.3.	Иргэн галт зэвсэг олсон бол түүнийг цагдаагийн байгууллагад шилжүүлэн өгнө.
34	47.1.	Иргэн улс, хот хооронд, орон нутагт агаарын хөлөг, хөлөг онгоц, галт тэрэг, бусад нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо галт зэвсэг авч явах бол галт зэвсгийг тухайн тээврийн хэрэгслийн дарга, эсхүл жолоочид хадгалуулна.
35	48.6.	Иргэн , хуулийн этгээд тооллого зохион байгуулагдах хугацаанд өөрийн өмчлөлд байгаа галт зэвсгийн болон иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хамт галт зэвсгийг биет байдлаар авч ирэн ажлын хэсэгт бүртгүүлнэ.
36	51.4.	Энэ хуулийн 51.2.1-д заасан үүргийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгийг цагдаагийн байгууллага зохих журмын дагуу хураан авна.

Хүснэгтэд дурдсанчлан төсөлд тусгагдсан иргэнд үүрэг болгосон бүх заалтууд нь хориглосон агуулгатай буюу эс үйлдэхүйг үүрэг болгосноороо иргэнд нэмэлт зардал гарах зохицуулалт биш байна.

Иймд **Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/** төсөл батлагдсанаар иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал болон зардал үүсэх зохицуулалт байхгүй тул тусгайлан зардал тооцох хэрэгцээ шаардлагагүй байна.

**Дөрөв. Галт зэвсгийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл
батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардал**

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг урьдчилан тооцох
- Зардлыг нэгтгэн тооцох
- Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хуулийн төсөлд **төрийн байгууллагад** үүрэг болгосон буюу шууд зардал үүсгэх болон шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж үзэж болох агуулга бүхий дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1	8.2.	Бусад улсаас Монгол Улсад төрийн өндөр хэмжээний айлчлал хийхэд, эсхүл энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургууль, дадлагыг Монгол Улсад зохион байгуулахад олон улсын байгууллага, гадаад улсын өмчлөлийн галт зэвсэг, сумыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх бол Тагнуулын ерөнхий газар, төрийн тусгай хамгаалалт хариуцсан байгууллагын болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хүсэлтийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.
2	9.3.	Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтыг цагдаагийн байгууллага зохион байгуулж, сургалтын зааврыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.
3	10.2.	Энэ хуульд өөрөөр заагаагүй бол 21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг эзэмших, ашиглах,

		хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, эсхүл цэргийн жинхэнэ алба хаасан, хууль сахиулах, аюулгүй байдлын боловсон хүчин бэлтгэх сургууль төгссөн ажилтан, байгаль хамгаалагч, харуул хамгаалалтын ажилтан, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллага гэрээний үндсэн дээр албаны үүрэг гүйцэтгэх хугацаанд нь галт зэвсэг эзэмшүүлж болно.
4	10.3.	Энэ хуулийн 10.1-д заасан харуул хамгаалалтын ажилтан, байгаль хамгаалагчид галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл эзэмшүүлэх гэрээг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.
5	12.7.	Галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллага олгоно.
6	14.1	Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид байгаль орчны газар гэх/ болон тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа /цаашид хамгаалалтын захиргаа гэх/ нь өөрийн өмчлөлийн галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг энэ хуулийн 9.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байгаль хамгаалагчид эзэмшүүлж, ашиглуулж болно.
7	14.2.	Аймаг, нийслэлийн байгаль орчны газар болон хамгаалалтын захиргаа нь 4,5 мм-ээс дээш 12,7 мм хүртэлх калибрийн бянттай болон гөлгөр гол төмөртэй, ажиллагааны хувьд гараар цэнэглэгддэг, автоматаар эсхүл өөрөө цэнэглэгдэх боломжгүй, хүхээгт нь арав, түүнээс цөөн сум орох багтаамжтай, үйлдвэрийн үндсэн хийцийг өөрчлөөгүй галт зэвсэг өмчилж, эзэмшиж, ашиглаж болно.
8	14.3.	Аймаг, нийслэлийн байгаль орчны газар болон хамгаалалтын захиргаа нь галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, гол төмөр худалдан авснаас хойш ажлын таван өдрийн дотор энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагад бүргүүлж гэрчилгээ авна.
9	14.6.	Аймаг, нийслэлийн байгаль орчны газар болон хамгаалалтын захиргаа нь өөрийн өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд нь хяналт тавьж, тооллогыг сар бүр явуулан тайлан мэдээг цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.
10	14.7.	Аймаг, нийслэлийн байгаль орчны газар болон хамгаалалтын захиргаа, байгаль хамаалагч нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг хадгална.

11	14.8.	Аймаг, нийслэлийн байгаль орчны газар болон хамгаалалтын захиргаа, байгаль хамаалагч нь өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бусад этгээдэд шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.
12	15.2.	Энэ хуулийн 9.1-д заасан иргэнийг галт зэвсгээр гэмт хэрэг санаатай үйлдэж ял эдэлж байгаагүй талаарх тодорхойлолтыг цагдаагийн байгууллага гаргаж, энэ хуулийн 14.1-д заасан баримт бичигт хавсаргана.
13	15.4.	Шүүх шинжилгээний байгууллага энэ хуулийн 4.1.1- 4.1.4-т заасан галт зэвсгээр буудсан сумны хонгио, хошуу тус бүрээс хоёрыг дээж болгон авч, тухайн галт зэвсэг болон түүнийг эзэмшигчийн талаарх мэдээллийг нэгдсэн санд бүртгэн оруулсны дараа цагдаагийн байгууллага ажлын таван өдрийн дотор галт зэвсгийг бүртгэх, галт зэвсгийн гэрчилгээ олгох эсэх асуудлаар шийдвэр гаргана.
14	15.5.	Монгол Улсын хилээр нийтэд худалдах зорилгоор оруулсан галт зэвсгийг худалдан борлуулахаас өмнө шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэн буудлага үйлдүүлж, сумны хонгио, хошууг нь мэдээллийн нэгдсэн санд авч бүртгүүлэх ажлыг цагдаагийн байгууллага зохион байгуулна.
15	15.7.	Харьяа сум, дүүрэгт шилжин ирсэн иргэний галт зэвсгийг бүртгэлд авсан талаар тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага шилжүүлсэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажлын арван өдрийн дотор мэдэгдэнэ.
16	15.9.	Цагдаагийн байгууллага нь нийтэд худалдах зорилгоор үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, устгасан, тээвэрлэсэн болон иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн нэр, төрөл, загвар, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сантай байна.
17	15.11.	Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн мэдээг сар бүр цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.
18	16.4.	Галт зэвсгийн тухай хуулийн 12.9 дэх хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллага нь нийтэд худалдах зорилгоор импортолсон, худалдсан, тээвэрлэсэн болон иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн гэрэл зураг, нэр, төрөл, загвар, сумны жин, тоо ширхэгийг тусгасан мэдээллийн сантай байна.
19	16.5.	Цагдаагийн байгууллага гаалийн байгууллагаас ирүүлсэн улсын хилээр нэвтрүүлсэн галт зэвсэгтэй адилтгах

		хэрэгслийн мэдээг тухай бүр мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулна.
20	17.1.	Энэ хуулийн 15 дугаар зүйлийн дагуу галт зэвсгээ бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдэд галт зэвсгийн гэрчилгээ олгоно
21	20.3.	Хууль зүйн, спорт, байгаль орчин, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, цагдаа, гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн, энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумыг хилээр оруулах зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий комисс /цаашид “Комисс” гэх/ хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.
22	20.4.	Комиссын дарга, нарийн бичгийн даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.
23	20.8.	Монгол Улсад галт зэвсэг, сум нийтэд худалдах төв /цаашид “Төв” гэх/ ажиллуулах эрхийг улсын хэмжээнд гурваас илүүгүй хуулийн этгээдэд олгох бөгөөд Төв ажиллуулах эрхийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
24	20.15.	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага хяналт тавина.
25	21.2.	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ хуулийн 21.1-д заасан саналыг үндэслэн шийдвэр гаргана.
26	21.3.	Төрийн захиргааны байгууллагаас томилогдсон Комиссын гишүүд комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар харьяалах байгууллагын удирдлагад мэдээлэл өгнө.
27	21.4.	Энэ хуулийн 20.3-т заасан Комиссын гишүүн, нарийн бичгийн даргад улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.3-т хэсэгт заасан нийслэлийн батлагдсан төсвөөс олгоно.
28	22.2.	Цагдаагийн байгууллага энэ хуулийн 22.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан иргэнд иргэний үнэмлэх, энэ хуулийн 12.6-т заасан өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудсыг үндэслэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгоно.
29	28.2.	Комисс нь сонгон шалгаруулалтын явцад оролцогчийн талаарх тодорхой мэдээлэлтэй газар дээр нь очиж

		танилцах буюу шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас авч болно.
30	28.3.	Комисс нь сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн материалуудыг хянан үзээд энэ хуульд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг дийлэнх олонхийн саналаар сонгож, санал дүгнэлтээ гаргана.
31	28.4.	Комисс нь материал хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 21 өдөрт багтаан сонгон шалгаруулалтыг хийж, санал, дүгнэлтээ гаргаж, Комиссын дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.
32	28.5.	Комисс нь шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтад шалгарсан тухай харин бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг Комиссын санал, дүгнэлт гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор өгнө.
33	30.3.	Комисс нь Төвийн салбар ажиллуулах байр, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/ аюулгүй байдлын болон бусад стандарт, дүрэм, журамд нийцэж байгаа эсэх талаар лавлагаа, мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас авч болно.
34	30.4.	Комисс нь салбар нээх тухай хуулийн этгээдийн хүсэлтийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах ба Комиссын санал, дүгнэлтийг үндэслэн Төвийн салбар нээх зөвшөөрөл олгох эсэхийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.
35	30.5.	Төвийн салбар нээх тусгай зөвшөөрлийг Төв ажиллуулах эрхийн хугацаатай ижил хугацаагаар олгоно.
36	32.2.	Энэ хуулийн 32.1-д заасан галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг олгох эсэхийг цагдаагийн байгууллага ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ.
37	33.3.	Цагдаагийн байгууллага энэ хуулийн 33.1-д заасан хүсэлтийг ажлын таван өдрийн дотор хянан үзэж, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.
38	33.5.	Энэ хуулийн 33.3-т заасны дагуу галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр оруулахад гаалийн байгууллага зөвшөөрлийн хуудсан дээр тэмдэглэгээ хийж, улсын хилээр буцаан гаргахад зөвшөөрлийн хуудсыг хураан авч, цагдаагийн төв байгууллагад улирал бүр хүргүүлнэ.

39	35.2.	Гаалийн газар, хороо нь мэдүүлгийг холбогдох бичиг баримтын хамт хүлээн авч, гаалийн хууль тогтоомжийн дагуу бичиг баримт болон бараанд шалгалт хийж, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.
40	35.3.	Улсын хилээр оруулсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн зөвшөөрөлд гаалийн газар, хороо тэмдэглэл хийж, гаалийн мэдүүлэгт хавсаргаж үлдээнэ.
41	35.4.	Гаалийн байгууллага нь галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, тэдгээрийн эд анги, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэхэд шаардлагатай бараа, эд зүйлийг улсын хилээр оруулсан мэдээллийг цагдаагийн төв байгууллагад дараа сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.
42	35.5.	Гаалийн хууль тогтоомжийн зөрчлийн улмаас хураагдсан, нягтлан шалгах зорилгоор саатуулагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн талаарх мэдээллийг гаалийн төв байгууллага ажлын таван өдрийн дотор цагдаагийн төв байгууллагад ирүүлнэ.
43	36.4.	Энэ хуулийн 36.3-т заасан аюулгүйн бүсийг Комиссын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.
44	37.3.	Үйлдвэрлэсэн галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум, дахин цэнэглэлэгдсэн сумны сери /цуврал/ дугаар бүхий сав, баглаа боодолтой байх ба сери /цуврал/ дугаарыг цагдаагийн төв байгууллага олгож, хяналт тавина.
45	39.6.	Тирний шаардлага хангасан эсэхэд спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргаж, цагдаагийн байгууллага хяналт тавина.
46	44.1.	Дараах тохиолдолд эрх бүхий албан тушаалтан иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг хурааж, ажлын арван таван өдрийн дотор цагдаагийн байгууллагад хүргүүлнэ:
47	44.2.	Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх, мэдээллийн сан үүсгэх, ашиглах, судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт, холбогдох мэдээ, тайлан гаргах, сангийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг цагдаагийн байгууллага зохион байгуулна.

48	46.7.2.	өмчлөгчид буцаан олгох тухай эрх бүхий байгууллага, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан.
49	46.8.3.	үзмэр цуглуулгын зориулалттай галт зэвсгийг зориулалт бусаар ашигласан тохиолдолд холбогдох хууль сахиулах байгууллагад эзэмшүүлэхээр шилжүүлнэ.
50	46.9.	Байлдааны зориулалттайгаас бусад галт зэвсэг, сумыг сургалт, шинжилгээ, судалгаанд зориулан шүүхийн шинжилгээний болон хууль сахиулах алба хаагчийг бэлтгэх, давтан сургах чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ.
51	48.1.	Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн тооллогыг жил бүр цагдаагийн байгууллага улсын хэмжээнд зохион байгуулна.
52	48.3.	Энэ хуулийн 48.2-т заасан ажлын хэсэг нь галт зэвсгийн тооллого явуулах удирдамж, төлөвлөгөө гарган холбогдох алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллана.
53	48.5.	Энэ хуулийн 48.2-т заасан ажлын хэсэг галт зэвсгийн тооллогыг зохион байгуулахдаа бусад байгууллагатай хамтран ажиллаж, тооллого, бүртгэлийг зохион байгуулах ажилд бүх шатны Засаг дарга дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
54	49.1.	Галт зэвсгийн тухай хуулийн хэрэгжилтэд цагдаагийн байгууллага хяналт тавина.
55	49.2.	Цагдаа байгууллага нь галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны марк, ангилал, хүчин чадал, ашиглах хугацаа, стандартын чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагын туслалцааг авна.
56	51.4.	Энэ хуулийн 51.2.1-д заасан үүргийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгийг цагдаагийн байгууллага зохих журмын дагуу хураан авна.

Төсөлд тусгагдсан дээрх заалтууд нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Галт зэвсгийн тухай”-ийн харгалзах дугаар бүхий заалтуудад өмнө зохицуулагдсанаараа төсөл батлагдсанаар төрийн байгууллагад нэмэлт үүрэг ноогдуулж, нэмэлт зардал үүсгэхгүй зохицуулалтууд байна.

Мөн төсөлд тусгагдсан заалтууд нь өмнөх найруулгыг шинэчилж, зохицуулалтыг хуулийн төслийн үзэл баримтлалд заасантай уялдуулан боловсронгуй болгосон агуулгатай байна.

Тав. Дүгнэлт

“Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хууль” болон түүнтэй уялдуулан боловсруулсан хуулийн төслийн шинэчилсэн зохицуулалтууд нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй “Галт зэвсгийн тухай хууль”-ийн зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгосон, нарийвчилсан агуулгатай байгаагаараа иргэн, төрийн байгууллагад зардал үүсэхээр шинэ буюу нэмэлт үүрэг ноогдуулаагүй байна.

Харин Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх хуулийн этгээд нь үйл ажиллагааны эрсдэл, иргэний амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулсан байна.” гэж заасны дагуу галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь ажилтнуудаа даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээхээр, 18 дугаар зүйлийн 18.6-д “Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг **хуулийн этгээд** галт зэвсгийг өмчилж, эзэмшиж байгаа бол аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоноглогсон зориулалтын агуулахад галт зэвсэг, сумыг тус тусад нь хадгалах бөгөөд үйл ажиллагаагаа явуулдаг байр нь Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хамгаалалттай байна” гэж заасны дагуу хуулийн этгээдэд зардал гарах зохицуулалтууд тусгагдсан байна.

Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй бөгөөд нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй. хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлж, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл өмчлөх, эзэмших, ашиглах, үйлдвэрлэх эрхийг хангах, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг мөрдүүлэх, хууль бус хэрэглээг тодорхой болгон, гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байгаа галт зэвсгийн дийлэнх нь харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг байгааг харгалзан нийгэмд гарч байгаа сөрөг үр дагавар багасах ач холбогдолтой байна.

Мөн хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээдэд шинээр хүний нөөцийн хэрэгцээ шаардлага гарахгүй, улмаар хүний нөөцтэй холбоотойгоор цалингийн зардал гарахгүй гэж үзлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт өөрчлөлтүүд нь ихэнхдээ тухайн зохицуулалтыг боловсронгуй болгосон, зарим нэмэлт үүрэг нь одоо мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын зардлын хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох үүрэг байх тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал нэмэхгүй, төрийн байгууллага, иргэнд аливаа нэмэлт зардал гарахгүй гэж дүгнэж байна.

----oOo----

